

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код 13.030.40, 23.100.60

Бохир усан дахь өөх тос баригч төхөөрөмж. Техникийн ерөнхий шаардлага	MNS 5975 : 2009
Grease catcher equipment in waste water General requirements	

Стандартчилал, Хэмжилзүйн Үндэсний Зөвлөлийн 2009 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн 19 дүгээр тогтоолоор батлав.

Энэхүү стандарт нь 2009 оны 11 дүгээр сарын 13-ны өдрөөс эхлэн хүчинтэй.

1 Зорилго

Энэ стандартын зорилго нь нийтийн хоолны газар болон мах, махан бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрээс гарч буй хаягдал бохир усан дахь өөх тос (ханасан карбоны хүчил)-ийг барих төхөөрөмжид тавих техникийн ерөнхий шаардлагыг тогтооход оршино.

2 Хамрах хүрээ

Энэ стандарт нь энд тодорхойлсон тос баригч төхөөрөмжийг үйлдвэрлэх, ашиглахад хамаарна.

3 Нэр томьёо, тодорхойлолт

тос баригч төхөөрөмж

ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэгдэж буй бохир усан дахь өөх тос (ханасан карбоны хүчил)-ийг барих зориулалт бүхий төхөөрөмж

4 Тос баригч төхөөрөмжид тавих шаардлага

4.1 Тос баригч төхөөрөмжийн их бие (1)-ийг 1,5 мм-ээс 2,5 мм-ийн зузаантай төмрөөр 1-р хүснэгтэд үзүүлсэн хэмжээгээр үйлдвэрлэх ба “А” Хавсралтад үндсэн хэлбэрийг үзүүлсэн болно.

4.2 Тос баригч төхөөрөмжийн дөрвөн тал хэсэг болон ус орох, гарах хоолойг нийлүүлж гагнасны дараа гагнаасаараа ус гоожихгүй, шүүрэхгүй байна.

4.3 Тос баригч төхөөрөмжөөр цэвэрлэгдэн гарсан хаягдал бохир ус нь MNS 4349 : 2000 стандартын шаардлагад нийцсэн байна.

Тос баригч төхөөрөмжийн техникийн
үндсэн үзүүлэлт

1-р хүснэгт

Д/д	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Ангилал		
			I	II	III
1.	Хүчин чадал	м ³ /хоног	8	16	54, 140
2.	Суудлын тоо	суудал	20-100	100-200	200 –аас дээш
3.	Савны өндөр /A/	мм	250	310	750
4.	Савны өргөн /B/	мм	250	310	750
5.	Савны урт /C/	мм	310	310	930
6.	Орох хоолойн доод түвшин /D/	мм	170	215	510
7.	Гарах хоолойн доод түвшин /F/	мм	155	200	465
8.	Дамжуулах хоолойн голч	мм	50	50	100, 150
9.	Тос цуглуулах савны багтаамж	л	1,5	2	4.5

5 Аюулгүй байдлын шаардлага

- 5.1** Тэгш хэвтээ түвшинд суурилагдсан байна.
- 5.2** Тос цуглуулах сав нь тосоор дүүрсэн эсэхийг шалгана. Өдөрт нэг удаа цэвэрлэнэ.
- 5.3** Орох гарах хоолойгоор ус алдаж байгаа эсэхэд үзлэг хийнэ.
- 5.4** Тос баригч төхөөрөмжийн таглаатай эсэхийг шалгана.

6 Шалгалт, баталгаажуулалт

- 6.1** Тос баригч төхөөрөмжийг ердийн аргаар усаар дүүргэж, гоожилт, шүүрэлтийг шалгана. Ус гоожихгүй, шүүрэхгүй тохиолдолд ашиглалтад тэнцэнэ гэж үзэж В хавсралтад заасан чанарын мэдэгдэл олгоно.
- 6.2** Тос баригч төхөөрөмж нь ус дамжин өнгөрөх үндсэн сав, орох гарах хоолой, өөх, тос цуглуулах сав, 4 төрлийн хаалт, хавтан, таг, хөл зэргээс иж бүрдэл болно.


7 Савлалт, хаяглалт

7.1 Төхөөрөмж дээр дараах агуулга бүхий шошгыг бэхэлсэн байна. Үүнд:


- Үйлдвэрлэгчийн нэр
- Бүтээгдэхүүний нэр
- Үйлдвэрлэсэн огноо
- Харилцах утасны дугаар
- Энэхүү стандартын дугаар

ТӨГСӨВ.

А хавсралт (мэдээллийн)




а) Орох хоолой




б) Гарах хоолой

А.1-р зураг Тос баригч төхөөрөмжийн үндсэн хэлбэр /нүүр хэсэг/




а) Зүсэлт



б) Таг

А.2-р зураг Тос баригч төхөөрөмжийн үндсэн хэлбэр

А хавсралт (мэдээллийн) үргэлжлэл



а) Технологийн схем

б) Ерөнхий харагдах байдал

А.3-р зураг Тос баригч төхөөрөмж

В хавсралт (мэдээллийн)

Тос баригч төхөөрөмжийн чанарын мэдэгдэл

1. Үйлдвэрлэгчийн нэр
2. Үйлдвэрлэсэн огноо
3. Баталгаажуулсан огноо
4. Борлуулсан огноо

Тос баригч төхөөрөмж нь MNS ... : 2009 стандартын шаардлага хангасан тул борлуулсан өдрөөс эхлэн сарын хугацаатай баталгаа олгов.

Үйлдвэрлэгчийн
Тамга, тэмдэг

..... он сар өдөр